



БИЕ ДААЛТЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ
АРГАЧИЛСАН ЗААВАР

Бие даалтын ажлын зорилго нь оюутнуудын онолын мэдлэгийг бататгах, ном, лавлах материалаас шаардлагатай сонголтыг бие даан хийж, инженерийн тооцоог гүйцэтгэх чадварыг эзэмшүүлэхэд оршино. Энэхүү ажил нь оюутны бие даалтын ажилд тооцогдоно.

Бие даалтын ажил нь нийт 8 даалгавраас тогтох бөгөөд оюутан нь ажлыг даалгаврын дугаарын дагуу дэс дараалан хийж гүйцэтгэнэ. Бие даалтын ажил нь "тайлбар-тооцоо" ба "график-зураг"-ийн гэсэн хоёр хэсгээс тогтоно. "Тайлбар-тооцоо" нь даалгавар тус бүрт хийж гүйцэтгэх тооцоог багтаасан үндсэн бичлэгээс тогтоно. Харин "зураг-график"-ийн хэсэгт 2-8 бүлэгт холбогдох зургийг А1 хэмжээтэй 2 ширхэг ватум цаасан дээр А4 болон А3 форматын хэмжээнд багтаан зурж дүрсэлнэ. Зурагт хэрэглэх хүснэгт 185x55 хэмжээтэй байна. Даалгаврын дугаарыг ромбо тоогоор бичив. Дээрхийг загварчилбал:



Эд ангийн хэвийн хэмжээний масштаб болон хүлцлийн талбайн хэмжээний масштаб нь өөр өөр байж болно. Зургийг техникийн шугам зурагт хэрэглэдэг стандартын шаардлагуудыг баримтлан хийж гүйцэтгэх ёстой. Ажлын явцыг хичээлийн хуваарьт заагдсан бие даалтын цагууд дээр багш үзэж, шалган, зөвлөгөө өгнө. Бие даалтын ажлыг багш тогтоосон хугацаанд даалгавар тус бүрээр нь шалгах бөгөөд хэрэв оюутан заасан хугацаанд шалгуулаагүй бол хугацаа хэтэрсэн өдөр бүрт **0.1** оноогоор бодож бие даалтын ажлын онооноос нь хасч тооцно. Хэрэв хүндэтгэх шалтгаантай бол түүнийгээ батлах баримтыг бүрдүүлсэн байх ёстой бөгөөд багшаас дахин заасан хугацаанд багтаан шалгуулсан байна.

Оюутан бүрт даалгаврын шифрийг өгөх бөгөөд уг шифрийн дагуу даалгаврын өгөгдлийн хүснэгтүүдээс харгалзах утгыг сонгон авна. Үүнийг жишээн дээр тайлбарлая. Оюутны гүйцэтгэх даалгаврын шифр "3-6" гэвэл 3-нь вариантын дугаарыг, 6- нь группийн дугаарыг тус тус заана.

Вариант №	Тэмдэглэгээ		Групп							
			1	2	3	4	5	6	...	10
1										
2										
3										
...										
10										

Ангийн ажлыг хийж гүйцэтгэх аргачлалыг даалгавар тус бүр дээр тайлбарлан хийх ажлын дарааллыг жишээний хамт тайлбарлан үзүүлэв.

Даалгавар № 1.
Гөлгөр цилиндр харьцалтын хүлцэл суултын тооцоо

1. Эд ангийн хэмжээ, хүлцэл суултын үндсэн хэмжээсүүдийг тодорхойлох
 - Нүх ба голын хязгаарын хазайлтуудыг тодорхойлох (ES, EI, es, ei)
 - Холбоосын суултын хязгаарын утгуудыг тодорхойлох
($S_{max}, S_{min}, N_{max}, N_{min}$)
 - Нүх ба голын хязгаарын хэмжээсүүдийг тодорхойлох
($D_{max}, D_{min}, d_{max}, d_{min}$)
2. Дээрх харьцалтаар ямар төрлийн суулт үүсч байгааг тайлбарлан бичих.
3. Хүлцлийн талбайн график зургийг зурж, зохих тэмдэглэгээг хийх.

Жишээ. 1

Өгөгдөл: $D=d=36$ мм; h - голын систем; $N_{max}=0.03$ мм; $T_d=0.08$ мм;
 $T_D=0.12$ мм

Тодорхойлох утгууд:

$$D_{max}, D_{min}, d_{max}, d_{min}, ES, EI, es, ei, S_{max}, S_{min}, N_{min} = ?$$

Бодолт:

1. Голын системийн хувьд гол нь үндсэн эд анги болох тул мөрдлөгөөр хэмжээний дээд хазайлт $es=0$ болно.

а) Тэгвэл хэмжээний дээд хазайлт нь:

$$T_d = es - ei \Rightarrow ei = es - T_d = 0 - 0.08 = -0.08 \text{ мм} = -80 \text{ мкм}$$

б) Голын хязгаарын хэмжээсүүдийн утгуудыг тодорхойлъё.

$$d_{max} = d + es = 36 + 0 = 36 \text{ мм} \quad d_{min} = d + ei = 36 - 0.08 = 35.92 \text{ мм}$$

в) Нүхний хязгаарын хэмжээсүүдийн утгуудыг тодорхойлъё.

$$N_{max} = d_{max} - D_{min} \Rightarrow D_{min} = d_{max} - N_{max} = 36 - 0.03 = 35.97 \text{ мм}$$

г) Нүхний хэмжээний хязгаарын хазайлтыг тодорхойлъё.

$$D_{max} = D_{min} + T_D = 35.97 + 0.12 = 36.09 \text{ мм}$$

д) Нүхний хэмжээний хязгаарын хазайлтыг тодорхойлъё.

$$ES = D_{max} - D = 36.09 - 36 = 0.09 \text{ мм} = 90 \text{ мкм}$$


$$EI = D_{min} - D = 35.97 - 36 = -0.03 \text{ мм} = -30 \text{ мкм}$$

е) Суултын хамгийн бага чийргын утгыг тодорхойлъё.

$$N_{min} = d_{min} - D_{max} = 35.92 - 36.09 = -0.17 \text{ мм} = -170 \text{ мкм} = -S_{max}$$

2. Дээрх тооцооноос үзвэл $S_{max}=0.17$ мм, $N_{max}=0.03$ мм бүхий завсрын суултаар холбогдсон голын системийн холбоос болж байна.

3. Хүлцлийн талбайн график зургийг зурвал:



Даалгавар № 2.
Эд ангийн суултын нарийвчлалын
ангийг тодорхойлох

Даалгаврыг хийснээр холбоосын өгөгдсөн ашиглалтын утгуудын үндсэн дээр стандартын суултын нарийвчлалын ангийг нь тодорхойлох тооцооны аргыг эзэмших, стандартын суултын сонголтыг хийх чадварыг суралцана. Даалгаврыг гүйцэтгэх дараалал:

1. Өгөгдсөн ашиглалтын суултын зай(чийрга)-н хязгаарын утгуудаар тухайн суултын хүлцлийг тодорхойлох. $T_S(T_N)=?$

2. Хэмжээний хүлцлийн нэгжийг тодорхойлох. $i=?$

3. Хэмжээний хүлцлийн нэгжийн тоог тодорхойлж, стандартын утганд шилжүүлэх. $a=?, a_{CT}=?$

4. Эд ангийн хэвийн хэмжээ болон хүлцлийн нэгжийн тооноос хамааруулан нарийвчлалын ангийг нь тодорхойлох. $IT?$

5. Өгөгдсөн ашиглалтын зай(чийрга)-н дундаж утгын олох. $S'_m(N'_m)=?$

6. Тодорхойлсон нарийвчлалын ангид хамаарах стандартын зай (завсрын болон чийрга)-тай суултуудыг [1] номын 1.47 хүснэгтээс (завсрын суултыг 1.48 хүснэгт, чийрга суултыг 1.49 хүснэгтээс) бүгдийг нь тэмдэглэн авч зай (завсрын ба чийрга)-н дундаж утгуудыг нь тодорхойлох.

$$S_m(N_m)=?$$

7. Олсон дундаж утгуудыг урьд тодорхойлсон ашиглалтын зай(чийрга)-н дундаж утгатай жишиж, хамгийн ойролцоо байгаа стандартын утгаар стандартын суултыг сонгон авах. $S_m(N_m) \approx S'_m(N'_m)$

8. Сонгон авсан стандартын суултуудыг нүхний системийн үндсэн нүхний хязгаарын хазайлтыг [1] номын 1.27 хүснэгтээс, голын хязгаарын хазайлтыг суултын төрлөөс нь хамааруулан 1.28-30 хүснэгтүүдийн аль нэгээс, харин голын системийн үндсэн голын хязгаарын хазайлтыг [1] номын 1.35 хүснэгтээс, нүхний хязгаарын хазайлтыг суултын төрлөөс нь хамааруулан 1.36-1.38 хүснэгтүүдээс харгалзуулан сонгон авч, хязгаарын хэмжээсүүдийг тодорхойлох.

9. Энэ суултын хүлцлийн талбайн график зургийг зурах.

Жишээ. 2

Өгөгдөл: $D=d=45$ мм; Н- нүхний систем; $S_{\max}=0.081$ мм; $S_{\min}=0.027$ мм;

$$i=?, a=?, a_{CT}=?, IT?, S_m=?,$$

$$S'_m=?, ES, EI, es, ei, T_D=?,$$

$$T_d=?, D_{\max}, D_{\min}, d_{\max}, d_{\min}-?$$

Бодолт: Нүхний системийн зайтай суулт өгөгджээ.

1. Суултын хүлцлийг тодорхойлъё.

$$T_s = S_{\max} - S_{\min} = 0.081 - 0.027 = 0.054 \text{ мм} = 54 \text{ мкм}$$

2. Хүлцлийн нэгжийн утгыг тодорхойлъё.

$$i = 0.45 * \sqrt[3]{D_m} + 0.001 * D_m ;$$

$$D_m = \sqrt{D_{\max}^x * D_{\min}^x} = \sqrt{50 * 30} = 38.73 \text{ мм}$$

$$i = 0.45 * \sqrt[3]{38.73} + 0.001 * 38.73 = 1.5255 + 0.038 = 1.564 \text{ мкм}$$

D_{\max}^x, D_{\min}^x -ийг СТ СЭВ145-75-аас хэвийн хэмжээний мужийн дээд ба доод хязгаарын утгаар [1] номын 1.8 хүснэгтээс сонгон авна.

3. Хүлцлийн нэгжийн тоог олж, түүнийг стандартын утганд шилжүүлъя.

Хоёр эд анги харьцаж байгаа тул дараахь томъёог ашиглана. $T_s = 2 * a * i$;

Эндээс: $a = T_s / (2 * i) = 54 / (2 * 1.564) \approx 17.26$; $a = 17.26$ болно. [1] номын 1.8

хүснэгтээс стандартын утгыг $a_{CT} = 16$ гэж авлаа.

4. Нарийвчлалын ангийг тодорхойлъё. [1] номын 1.8 хүснэгт /СТСЭВ145-

75, СТ СЭВ177-75/-ээс харвал хүлцлийн нэгжийн тоо $a_{CT} = 16$ байхад

түүнд харгалзах нарийвчлалын анги нь IT7 болно.

Суултын үндсэн нүх нь H7 нарийвчлалын ангиар хийгдэнэ.

5. Ашиглалтын зайн дундаж хэмжээг олбол:

$$S_m^a = \frac{S_{\max}^a + S_{\min}^a}{2} = \frac{0.081 + 0.027}{2} = 0.054 \text{ мм} = 54 \text{ мкм} \text{ болно.}$$

6. Стандартын суултуудын зайн дундаж хэмжээг олъё.

IT	$\frac{H7}{d8}$	$\frac{H7}{e7}$	$\frac{H7}{e8}$	$\frac{H7}{f7}$	$\frac{H7}{g6}$	$\frac{H7}{h6}$
S						
S_{max}	144	100	114	75	50	41
S_{min}	80	50	50	25	9	0
S_m	112	75	82	50	29.5	20.5

7. Суултуудын зайн дундаж утгуудыг ашиглалтын зайн утгатай жишиж, ойролцоогоор тэнцүү байгаа утгаар суултыг сонгон авна..

$S_m^a = 54$ мкм $\approx S_m = 50$ мкм тул дээрх хүснэгтээс **H7/f7** суултыг сонгон авлаа.

8. Сонгон авсан суултын хязгаарын хазайлтыг сонгон авбал:

H7 - д: ES=25 мкм; EI= 0 мкм;

f7 - д: es= -25 мкм; ei= -50 мкм

Нүх ба голын хэмжээний хүлцэл, хязгаарын хэмжээсүүдийг олбол:

$$T_D = 25 - 0 = 25 \text{ мкм};$$


$$T_d = -25 - (-50) = 25$$

мкм

$$D_{max} = D + ES = 45 + 0.025 = 45.025 \text{ мм}; \quad D_{min} = D + EI = 45 + 0 = 45 \text{ мм}$$

$$d_{max} = d + es = 45 - 0.025 = 44.975 \text{ мм}; \quad d_{min} = d + ei = 45 - 0.05 = 44.95 \text{ мм}$$

9. Хүлцлийн талбайн график зургийг зурвал:



Даалгавар № 3.

Өнхрөх холхивчийн суултын тооцоо

Машин, механизмын дамжуулагч голын үндсэн тулгуур эд анги болох өнхрөх холхивчийн дотоод ба гадаад цагирагуудын гол ба нүхтэй харгалзан харьцахад үүсэх суултуудын үндсэн тооцоог хийж сурах зорилготой. Даалгаврыг гүйцэтгэх дараалал:

1. Өгөгдсөн нэг эгнээ радиус үрлэн холхивчийн дугаар (тэмдэглэгээ)-ын дагуу [4] номын хавсралт.14-өөс холхивчийн дотоод(d) ба гадаад(D) цагирагийн диаметр, өргөн(B), өнхрөх үрлийн диаметр($D_{\text{вр}}$) болон налуу (r)-г тэмдэглэж авна.

2. Өгөгдөлд байгаа (Г.Ц- гадаад цагираг), эсвэл (Д.Ц- дотоод цагираг) гэсэн тэмдэглэгээ нь эргэлдэх цагирагийг зааж байгаа болно. Холхивчийн ажиллах ачааллыг тогтмол чиглэлтэй гэж үзэх ба [2] номын 4.88 хүснэгтээс ажлын үед цагирагууд дээр үүсэх ачааллын хэлбэрийг сонгон авна. Тэнхлэг ачаалал үүсэхгүй, харьцах голыг цул гэж тооцно.

3. Холхивчийн төрөл, нарийвчлалын анги(P0-P6)-ас хамааруулан холхивчийн өргөн, дотоод ба гадаад цагирагуудын хэмжээний хязгаарын хазайлтуудыг [2] номын 4.82 - 4.83 хүснэгтээс тус тус сонгон авна.

4. Өнхрөх холхивчийн эргэж буй цагираг нь хувьсах ачаалалд ажиллаж байгаа тул түүнтэй харьцах эд анг(гол, эсвэл нүх)-ийн нарийвчлалын ангийг ачааллын эрчим(P_R)-ийг тооцоолох замаар тодорхойлно. Олсон ачааллын эрчим ба эргэж буй цагирагийн диаметртээс хамааруулан [2] номын 4.92 хүснэгтээс харьцах эд ангийн нарийвчлалын ангийг сонгон авна. Дараа нь хэмжээний хязгаарын хазайлтууд(голын хувьд [1] номын 1.29 хүснэгт, нүхний хувьд [1] номын 1.37 хүснэгт)-ыг сонгон авна.

5. Өнхрөх холхивчийн эргэхгүй цагирагтай харьцах эд анг (гол, нүх)-ийн нарийвчлалын ангийг [2] номын 4.89 хүснэгтээс цагирагийн диаметр болон хэт ачааллын хув(%) -иас хамааруулан сонгон авна. Хэмжээний хязгаарын хазайлтууд(голын хувьд [1] номын 1.27-1.29 хүснэгт, нүхний хувьд [1] номын 1.35-1.37 хүснэгтээс сонгоно)-ыг сонгоно.

6. Өнхрөх холхивчийн гол ба их бие(нүх)-тэй харьцаж буй угсармал зургийг зурж, түүн дээр хүлцлийн талбайн график зургийг дүрслэн, зохих тэмдэглэгээг хийнэ.

Жишээ. 3.

Өгөгдөл: Холхивчийн дугаар 108
Холхивчийн нарийвчлалын анги Р6
Хэт ачаалал - 144%
Радиус ачаалал 5400 Н; Д.Ц hB?; KB?; IT_{Гол}?; IT_{НҮХ}?

Бодолт: Өгөгдсөн дугаарын холхивч нь хэвийн өргөнтэй хамгийн хөнгөн цувралын нэг эгнээ радиус үрлэн өнхрөх холхивч болно.

1. Өнхрөх холхивчийн хэмжээсүүдийг тэмдэглэн авбал:

$$d = 40 \text{ мм}; \quad D = 68 \text{ мм}; \quad B = 15 \text{ мм}; \quad d_2 = 49.7 \text{ мм};$$

$$D_2 = 59.3 \text{ мм}; \quad D_{\text{ҮР}} = 7.94; \quad r = 1.5 \text{ мм}$$

2. Д.Ц- дотоод цагираг эргэлдэж байгаа болно. Холхивчийн ажиллах ачааллыг тогтмол чиглэлтэй бөгөөд [2] номын 4.88 хүснэгтээс харахад гадаад цагираг нь байнгын ачаалалд, харин дотоод цагираг нь хувьсах ачаалалд ажиллаж байна. Ажлын үед тэнхлэг ачаалал үүсэхгүй гэж тооцов. Холхивч суух голыг цул гэж тооцно.

3. Холхивчийн төрөл, нарийвчлалын анги(Р6)-ас хамааруулан түүний өргөн, дотоод болон гадаад цагираг тус бүрийн хэмжээний хязгаарын хазайлтуудыг авбал:

Дотоод цагирагийн хязгаарын хазайлт (**KB**):

$$E_{SKB} = 0 \text{ мкм}; \quad E_{IKB} = -10 \text{ мкм};$$

Өргөний хязгаарын хазайлт (**TB**):

$$e_{sB} = 0 \text{ мкм}; \quad e_{iB} = -120 \text{ мкм};$$

Гадаад цагирагийн хязгаарын хазайлт (**hB**):

$$e_{shB} = 0 \text{ мкм}; \quad e_{ihB} = -9 \text{ мкм}$$

4. Өнхрөх холхивчийн дотоод цагираг эргэлдэж, хувьсах ачаалалд ажиллаж байгаа тул түүнтэй харьцах голын нарийвчлалын ангийг ачааллын эрчим(P_R)-ийг тооцоолох замаар тодорхойлно.

$$P_R = \frac{R}{b} k_i F F_A = \frac{5.4}{12 * 10^{-3}} * 1 * 1 * 1 = 450 \text{ кН/м}$$


[2] номын 4.92 хүснэгтээс голын нарийвчлалын ангийг сонгон авбал "k5", "k6" болно. Үүнээс "k6" гэж сонгов. [1] номын 1.29 хүснэгтээс:

$$k6\text{-д:} \quad e_s = +18 \text{ мкм}; \quad e_i = +2 \text{ мкм}; \quad T_d = 16 \text{ мкм}$$

5. Өнхрөх холхивчийн эргэхгүй байгаа гадаад цагирагтай харьцах нүхний нарийвчлалын ангийг гадаад цагирагийн хэмжээ $D = 68 \text{ мм}$, хэт ачаалал 150%-оос бага, үл задрах их биетэй гэж үзээд [2] номын 4.89 хүснэгтээс авбал: "H6", "H7" болно. Үүнээс "H7" гэж сонгов. [1] номын 1.35 хүснэгтээс:

$$\text{H7-д: } ES = +30 \text{ мкм; } EI = 0 \text{ мкм; } T_D = 30 \text{ мкм}$$

6. Өнхрөх холхивчийн хүлцлийн талбайн график зургийг дүрслэн, зохих тэмдэглэгээг хийнэ.



Даалгавар № 4.
Эрээсэн холбоосын хүлцэл, суултын тооцоо

Өргөн хэрэглэгддэг метрийн эрээсийн харьцалтын хүлцэл, суултын тооцоог хийж, хүлцлийн зургийг зурж сурах зорилготой. Даалгаврыг гүйцэтгэх дараалал:

1. Өгөгдсөн эрээсийн диаметр, алхамын утгаар эрэг ба боолтын дотоод болон дундаж диаметрийн утгуудыг бодож олно. Үүний тулд [2]-ийн 4.24 хүснэгтэнд буй харгалзах томъёог ашиглана.

2. Эрээсийн хүрээний зүслэгийн өндрийн тооцоог мөн дээрх хүснэгтийн дээд талын зургийн хэмжээсийн дагуу гүйцэтгэнэ.

3. Өгөгдсөн суултын төрлөөс хамааруулан боолт ба эрэгний хэмжээний хязгаарын хазайлтуудыг зайтай суултыг [2] номын СТ СЭВ 640-77(4.29 хүснэгт)-оос, завсрын суултыг СТ СЭВ 305-76(4.36 хүснэгт)-аас, чийрга суултыг СТ СЭВ 306-76(4.35 хүснэгт)-аас эрээсийн алхамаас нь хамааруулан тус тус сонгон авна.

4. Боолт, эрэгний харьцалтын үеийн эрээсийн хүрээний зүслэгийн зургийг [2] номын 4.24 хүснэгтэнд байгаа зургийг ашиглан өмнө хийсэн тооцооны дагуу зурна. Боолт ба эрэгний хүлцлийн талбайн зургийг энэ эрээсийн зүслэгийн зураг дээр зурж, зохих тэмдэглэгээг хийнэ. Хүлцлийн талбайн зураг зурах аргачлалыг жишээн дээрх аргачлалын дагуу хийнэ.

Жишээ. 4

Өгөгдөл:

$$D = d = 40 \text{ мм}; \quad \frac{6H}{6g}$$
$$P = 2 \text{ мм};$$

$$D_2, d_2, D_1, d_1, H = ?$$

Бодолт: Боолт ба эрэгний эрээсийн гадаад диаметр өгөгджээ. Суултын төрөл нь зайтай суулт болно.

1. Эрээсний үндсэн хэмжээсүүдийг олбол:

Эрээсний алхам $P=2$ мм бол:

$$D_2 = d_2 = d - 1 + 0.701 = 40 - 1 + 0.701 = 39.701 \text{ мм}$$

$$D_1 = d_1 = d - 3 + 0.835 = 40 - 3 + 0.835 = 37.835 \text{ мм}$$

$$D_2 = d_2 = 39.701 \text{ мм}; \quad D_1 = d_1 = 37.835 \text{ мм}$$

2. Эрээсийн хүрээний зүслэгийн өндрийг тодорхойлно.

$$H = 0.8660254 * P = 0.8660254 * 2 = 1.7320508 \text{ мм};$$

$$H_1 = 0.5412659 * 2 = 1.0825318 \text{ мм}$$

$$R = H / 6 = 0.1443276 * P = 0.1443276 * 2 = 0.2886552 \text{ мм};$$

$$H / 8 = 1.7320508 / 8 = 0.21650635 \text{ мм};$$

$$H/4 = 1.7320508 / 4 = 0.4330127 \text{ мм}$$

$$3H / 8 = 3 * 1.7320508 / 8 = 0.64951905 \text{ мм}$$

3. Өгөгдсөн $\frac{6H}{6g}$ суултанд өгөгдсөн эрэг ба боолтын хэмжээсүүдийн

хязгаарын хазайлтуудыг олъё. $\frac{6H}{6g}$ гэдэг нь $\frac{6H6H}{6g6g}$ буюу $\frac{D_2D_1}{d_2d}$

болно.

D_2 -ийн хувьд: $6H$ нь: $ES = 224 \text{ мкм}; EI = 0 \text{ мкм}$

D_1 -ийн хувьд: $6H$ нь: $ES = 224 \text{ мкм}; EI = 0 \text{ мкм}$

d_2 -ийн хувьд: $6g$ нь: $es = -38 \text{ мкм}; ei = -208 \text{ мкм}$


d -ийн хувьд: $6g$ нь: $es = -38 \text{ мкм}; ei = -318 \text{ мкм}$

4. Эрээсийн хүлцлийн талбайн зургийг зурна. Үүний тулд:

- Өөрийн сонгосон масштабаар эрээсийн хүрээний зүслэгийн зургийг 60^0 -ийн метрийн эрээсийн хувьд зурна.
- Эрээсийн дундаж диаметрийн "O" цэгийг дайруулан эгц босоо "n-n" шулуун татна.
- Эрээсийн гадаад, дундаж болон дотоод диаметруудийн шугамууд дээр хязгаарын хазайлтуудаар нь хүлцлийн талбайн зургийг зурна
- Боолтны эрээсийн хүрээний дагуух хүлцлийн талбайн зургийг дүрслэхдээ дундаж диаметрийн "6g" хязгаарын дээд ба доод хазайлтуудыг дайруулан хэвтээ шулуун татаж, босоо "n-n" шугамтай огтлолцуулна. Огтлолын цэгүүдийг дайруулан эрээсийн хүрээний шугамтай параллель налуу шугамууд татна. Дараа нь гадаад диаметрийн "6g" хязгаарын дээд ба доод хазайлтуудыг дайруулан хэвтээ шулуунууд татаж, өмнө татсан налуу шугамуудтай огтлолцуулан (дээд

хазайлтын шугамуудыг хооронд нь, доод хазайлтын шугамуудыг хооронд нь) зурж, эдгээр шугамуудаар хязгаарлагдсан хүрээг ташуу шугамаар тэмдэглэнэ.

- Эрэгний эрээсийн хүрээний дагуух хүлцлийн талбайн зургийг дүрслэхдээ дундаж диаметрийн "6H" хязгаарын дээд ба доод хазайлтуудыг дайруулан хэвтээ шулуун татаж, босоо "n-n" шугамтай огтлолцуулна. Огтлолын цэгүүдийг дайруулан эрээсийн хүрээний шугамтай параллель налуу шугамууд татна. Дараа нь дотоод диаметрийн "6H" хязгаарын дээд ба доод хазайлтуудыг дайруулан мөн хэвтээ шулуунууд татаж, өмнө татсан налуу шугамуудтай огтлолцуулан(дээд хазайлтын шугамуудыг хооронд нь, доод хазайлтын шугамууд хооронд нь) зурж, эдгээр шугамуудаар хязгаарлагдсан хүрээг ташуу шугамаар тэмдэглэнэ.



Даалгавар №5.

Тэвхэн холбоосын хүлцэл, суултын тооцоо

Хамгийн өргөн хэрэглэгддэг холбоос болох тэвхэн холбоосийн хэмжээсүүдийн хязгаарын хазайлтуудыг сонгон авах тооцоог хийж, хүлцлийн талбайн зургийг зурж сурах зорилготой. Даалгаврыг гүйцэтгэх дараалал:

1. Өгөгдсөн тэвхний өргөн(ϵ)-өөс хамааруулан [2] номын 4.64 хүснэгтээс тэвхний өндөр (h), урт(l), тэвх суух гол ба цэнгийн диаметр болон тэдгээрт суух хоног(t_1), ховилын гүний хэмжээсүүд (t_2)-ийг сонгоно.

2. Гол, цөн болон тэвхний хэвийн хэмжээсүүдийн хязгаарын хазайлтуудыг СТ СЭВ 144-75, СТ СЭВ 145-75 болон [2] номын 4.66 хүснэгтээс тус тус сонгоно.

3. Тэвхэн холбоосын угсаргааны зургийг зурж, хүлцлийн талбайн график зургийг дүрсэлж, зохих тэмдэглэгээг хийнэ.

📖 Жишээ. 5

Өгөгдөл:

$$b = 18 \text{ мм}$$
$$\text{ТЦ -J}_9; \text{ ТГ -N}_9; \text{ ТГ -h}_9$$

Зөв сонголт

1. Тэвхний өргөн: $\epsilon = 18 \text{ мм}$ бол:

Тэвхний өндөр: $h = 11 \text{ мм}$; урт: $l = 63 \text{ мм}$; фаска: $s = 0.5 \text{ мм}$;

Голын хоногийн хэмжээ: $t_1 = 7 \text{ мм}$;

Цэнгийн ховилын хэмжээ: $t_2 = 4.4 \text{ мм}$

2. Хэмжээсүүдийн хязгаарын хазайлтууд:

Тэвхний өргөн- ϵ : h9-д: $es = 0 \text{ мкм}$; $ei = -52 \text{ мкм}$; $TB = 52 \text{ мкм}$

Тэвхний өндөр- h : h11-д: $es = 0 \text{ мкм}$; $ei = -110 \text{ мкм}$; $TB = 110 \text{ мкм}$

Тэвхний урт - l : h14-д: $es = 0 \text{ мкм}$; $ei = -740 \text{ мкм}$; $TB = -740 \text{ мкм}$

Голын хоногийн өргөн- ϵ :

N9-д: $ES = 0 \text{ мкм}$; $EI = -52 \text{ мкм}$; $TГ = 52 \text{ мкм}$

Цэнгийн ховилын өргөн- ϵ :

J9-д: $ES = 26 \text{ мкм}$; $EI = -26 \text{ мкм}$; $TЦ = 52 \text{ мкм}$

Голын хоногийн урт - l :


H15-д: $ES = 1200 \text{ мкм}$; $EI = 0 \text{ мкм}$; $TГ = 1200 \text{ мкм}$

Голын хоногт суух гүн: - t_1 :

$ES = 200 \text{ мкм}$; $EI = 0 \text{ мкм}$; $T_{t1} = 200 \text{ мкм}$

Цэнгийн ховилд суух гүн: - t_2 :

$ES = 200 \text{ мкм}$; $EI = 0 \text{ мкм}$; $T_{t2} = 200 \text{ мкм}$



Даалгавар № 6.

Горивон холбоосын хүлцэл, суултын тооцоо

Түгээмэл хэрэглэгддэг холбоосын нэг болох горивон холбоосийн хэмжээсийн хязгаарын хазайлтуудыг сонгон авах тооцоог хийж, хүлцлийн талбайн зургийг зурж сурах зорилготой. Даалгаврыг гүйцэтгэх дараалал:

1. Призм хэлбэрт горивон холбоосын хэмжээсүүдийг [2] номын 4.71 хүснэгтээс тэмдэглэн авна.
2. Призм хэлбэрт горивон холбоосын хэмжээсүүдийн хязгаарын хазайлтыг СТ СЭВ 144-75, СТ СЭВ 145-75, эвольвент горивон холбоосын хязгаарын хазайлтыг [2] номын 4.78 хүснэгтээс тус тус сонгоно.
3. Горивон холбоосын төвлөлтийн аргаас хамааруулан холбоосын зургийг зурж, хүлцлийн талбайн график зургийг дүрсэлнэ.
4. Дүгнэлт бичих.

Жишээ. 6

$$\text{Өгөгдсөн нь: } D - 8 * 36 * 40 \frac{H8}{h7} * 7 \frac{D9}{h9}$$

Бодолт: Өгөгдлөөс үзвэл уг холбоос нь гадаад диаметрээр төвлөсөн, призм хэлбэрт горивон холбоос юм.

1. Горивон холбоосын хэмжээсүүдийг тодорхойлбол:

$$z = 8; d = 36 \text{ мм}; D = 40 \text{ мм}; d = 7 \text{ мм}; d_1 = 34.5 \text{ мм}; a = 3.46 \text{ мм};$$

$$c = 0.4 \text{ мм}; \quad r = 0.3 \text{ мм} \text{ болно.}$$

2. - Гадаад диаметрийн хязгаарын хазайлт:

$$\text{Цэнгийн хувьд - } H8\text{-д: } ES = 39 \text{ мкм}; \quad EI = 0 \text{ мкм};$$

$$\text{Голын хувьд - } h7\text{-д: } es = 0 \text{ мкм}; \quad ei = -25 \text{ мкм};$$

- Шүдний өргөний хязгаарын хазайлт:

$$\text{Цэнгийн ховилд - } D9\text{-д: } ES = 76 \text{ мкм}; \quad EI = 40 \text{ мкм};$$


$$\text{Голын хоногт - } h9\text{-д: } es = 0 \text{ мкм}; \quad ei = -36 \text{ мкм};$$

- Дотоод диаметрийн хязгаарын хазайлт:

$$\text{Цэнгийн хувьд - } H12\text{-д: } ES = 250 \text{ мкм}; \quad EI = 0 \text{ мкм};$$

$$\text{Голын хувьд - } a11\text{-д: } es = -310 \text{ мкм}; \quad ei = -470 \text{ мкм};$$

3. Хүлцлийн талбайн график зургийг зурж, зохих тэмдэглэгээг хийнэ.



Даалгавар № 7.

Хэмжээний хэлхээсийн тооцоо

Эд анги, зангилааг угсрах аргачлал, угсаргааны үндсэн тооцоог хийж сурах зорилготой. Хэмжээний хэлхээсийн тооцоог шугаман хэмжээний хэлхээс дээр хийх бөгөөд даалгаварт бүрэн харилцан солилцолын зарчмыг хангах шууд ба урвуу гэсэн хоёр бодлого өгөгдсөн. Сондгой тоогоор эхэлсэн шифр бүхий оюутнууд урвуу бодлого, харин тэгш тоогоор эхэлсэн нь оюутнууд шууд бодлогыг бодно. Бодлогыг бүрэн харилцан солилцолын зарчмын "Максимум, минимум арга", "Магадлалын онолын арга" гэсэн хоёр үндсэн аргаар бодно.

Даалгаврыг гүйцэтгэх дараалал:

1. Өгөгдсөн A4 мөчийн хэвийн хэмжээний утгаар бусад бүрдүүлэгч мөч ба хаагч мөчийн хэвийн хэмжээсүүдийг зохих томъёонуудаар олно.

2. "Максимум, минимум" аргаар бодлогыг бодохдоо:

- урвуу бодлогонд бүрдүүлэгч мөчүүдийн мэдэгдэж буй хязгаарын хазайлтуудыг ашиглан хаагч мөчийн хязгаарын хазайлтуудыг олно.

- шууд бодлогын хувьд мэдэгдэж буй хаагч мөчийн хязгаарын утгуудыг ашиглан "Тэнцүү хүлцлийн арга" ба "Ижил нарийвчлалын ангийн хүлцлийн арга" гэсэн хоёр аргаар бүрдүүлэгч мөчүүдийн хязгаарын хазайлтуудыг тус тус олно.

3. "Магадлалын онолын арга"-аар бодлого бодохдоо:

- урвуу бодлогонд бүрдүүлэгч мөчүүдийн мэдэгдэж буй хязгаарын хазайлтуудыг ашиглан хаагч мөчийн хязгаарын хазайлтуудыг олно.

- шууд бодлогын хувьд мэдэгдэж буй хаагч мөчийн хязгаарын утгуудыг ашиглан "Тэнцүү хүлцлийн арга" ба "Ижил нарийвчлалын ангийн хүлцлийн арга" гэсэн хоёр аргаар бүрдүүлэгч мөчүүдийн хязгаарын хазайлтуудыг тус тус олно.

- Хэмжээний алдааны тархалт нь Гауссын хуульд захирагдана.

4. Өгөгдсөн хэмжээний хэлхээсийн зураг дээр бүх мөчүүдийн хүлцлийн талбайн зургийг зурж, зохих тэмдэглэгээг хийнэ. Ингэхдээ "Максимум, минимум арга", "Магадлалын онолын арга" гэсэн арга тус бүр дээр олсон хязгаарын хазайлтуудыг дүрсэлнэ.

Анхаарах зүйл: Хэмжээний хэлхээсийн зурагт байгаа стандартын өнхрөх холхивчийн диаметр, өргөн, тэдгээрийн хязгаарын хазайлтыг Даалгавар №3 хийж гүйцэтгэсэн утгуудаар сонгон авна.

Жишээ. 7. а. /Шууд бодлого/

Өгөгдөл:

$$A_1=14+1.3A_4+B; \quad A_2=14+1.3A_4+2B;$$

$$A_3=0.3A_4; \quad A_6=0.5A_4; \quad A_4= 45 \text{ мм};$$

$$esA_0= 1.36 \text{ мм}; \quad eiA_0= 0.8 \text{ мм};$$

$$B= 15 \text{ мм}; \quad T_B= 0.12 \text{ мм}$$

$$A_0 = ?; \quad TA_0 = ?; \quad \Delta SA_i = ?; \quad \Delta IA_i = ?$$

Бодолт: I.A. Тэнцүү хүлцлийн аргаар бодлогыг бодъё. Энэ арга нь стандартын хэмжээнээс бусад бүх бүрдүүлэгч мөчүүдийн хүлцэл нь тэнцүү байна гэж үздэг.

1. Бүх мөчийн хэвийн хэмжээсүүдийг олбол:

$$A_1=14+1.3A_4+B=14+1.3*45+15=87.5 \text{ мм};$$

$$A_1=87.5 \text{ мм}$$

$$A_2=14+1.3A_4+2B=14+1.3*45+ 2*15= 106.5 \text{ мм};$$

$$A_2= 102.5 \text{ мм}$$

$$A_3=0.3A_4 = 0.2*45= 13.5 \text{ мм};$$

$$A_3= 13.5 \text{ мм}$$

$$A_6=0.5A_4 = 0.2*45= 22.5 \text{ мм};$$

$$A_6= 22.5 \text{ мм}$$

$$A_5=A_1 -(A_3 +B+ A_4/2)=87.5 -(13.5+15+22.5)= 36.5 \text{ мм};$$

$$A_5= 36.5 \text{ мм}$$

$$A_0=A_2 -(A_3 +2B+A_6+ A_4/2)=102.5 -(13.5+2*15+22.5+22.5)= 14 \text{ мм};$$

$$TA_0= esA_0 - eiA_0= 1.36 - 0.8 = 0.56 \text{ мм};$$

$$TA_0= 0.56 \text{ мм}$$

2. Бүрдүүлэгч мөчүүдийн хүлцлүүдийг тодорхойлоход хэрэглэх томъёо нь $TA_j = \frac{TA_0 - 3 * T_B}{p - 1 - 3}$ болно. Дээрхи зангилаанд өнхрөх холхивч гурав байгаа тул хаагч мөчийн хүлцлээс $3 * T_B$ -г, нийт мөчийн тооноос 3-г тус тус хасч тооцно.

$$TA_j = \frac{TA_0 - 3 * T_B}{p - 1 - 3} = \frac{560 - 3 * 120}{11 - 1 - 3} = \frac{200}{7} = 28.57 \approx 29 \text{ мкм}$$

болно.

3. Энэ аргын мөрдлөг ёсоор бүрдүүлэгч мөч нь ихэсэх (багтаах)

бүрдүүлэгч мөч бол хүлцэл нь хязгаарын дээд утгатай тэнцүү, доод хазайлт нь тэгтэй тэнцүү байна гэж үзнэ. Харин багасах (багтах) мөчийн хувьд хүлцэл нь хязгаарын доод утгатай тэнцүү, дээд хазайлт нь тэгтэй тэнцүү гэж тооцно. Тэгвэл:

$$\begin{aligned} \Delta SA_1 &= 29 \text{ мкм}; & \Delta IA_1 &= 0 \text{ мкм}; & \Delta SA_2 &= 29 \text{ мкм}; & \Delta IA_2 &= 0 \text{ мкм} \\ \Delta SA_3 &= 0 \text{ мкм}; & \Delta IA_3 &= -29 \text{ мкм}; & \Delta SA_4 &= 0 \text{ мкм}; & \Delta IA_4 &= -29 \text{ мкм} \\ \Delta SA_5 &= 0 \text{ мкм}; & \Delta IA_5 &= -29 \text{ мкм}; & \Delta SA_6 &= 0 \text{ мкм}; & \Delta IA_6 &= -29 \text{ мкм} \end{aligned}$$

ЮМ

I.Б. Ижил нарийвчлалын ангийн хүлцлийн аргаар бодлогыг бодъё.

Энэ арга нь стандартын хэмжээнээс бусад бүх бүрдүүлэгч мөчүүдийн хүлцэл нь нэгэн ижил нарийвчлалын ангид хамаарагдана гэж үздэг.

1. Бүрдүүлэгч мөчүүдийн нарийвчлалын ангийг олбол:

$$a = \frac{TA_0 - 3 * T_B}{\sum_{j=1}^{m+n} i_j} \quad \text{Энд: } a - \text{хүлцлийн нэгжийн тоо;}$$

i_j - бүрдүүлэгч мөчүүдийн хүлцлийн нэгж, мкм

2. Бүрдүүлэгч мөч бүрийн хүлцлийн нэгжийг доорх томъёогоор олно.

$$\begin{aligned} \sum_{j=1}^{m+n} i_j &= \sum_{j=1}^m i_{j\text{Ихэс}} + \sum_{j=1}^n i_{j\text{Багас}} = \sum_{j=1}^m (0.45 * \sqrt[3]{A_m} + 0.001 * A_m)_{\text{ИИХЭ}} + \\ &+ \sum_{j=1}^n (0.45 * \sqrt[3]{A_m} + 0.001 * A_m)_{\text{БАГАСА}} \end{aligned}$$

- Ихэсэх мөчүүдийн хүлцлийн нэгжийг тодорхойлъё. A_1 ба A_2 мөчүүдийн хэмжээ нь нэгэн ижил хэвийн хэмжээний мужид оршиж байгаа тул:

A_1 ба A_2 мөчийн хувьд:

$$A_m = \sqrt{A_{\max} * A_{\min}} = \sqrt{80 * 120} = 97.98 \text{ мм}$$

$$i_{A_1} = i_{A_2} = 0.45 * \sqrt[3]{97.98} + 0.001 * 97.98 = 0.45 * 4.61 + 0.09798 = 2.17 \text{ мкм}$$

$$\sum_{j=1}^2 i_j = i_{A_1} + i_{A_2} = 2.17 + 2.17 = 4.34 \text{ мкм}$$

- Багасах мөчүүдийн хүлцлийн нэгжийг тодорхойлъё.

A_3 мөчийн хувьд:

$$A_m = \sqrt{A_{\max} * A_{\min}} = \sqrt{10 * 18} = 13.42 \text{ мм}$$

$$i_{A_3} = 0.45 * \sqrt[3]{13.42} + 0.001 * 13.42 = 0.45 * 2.38 + 0.01342 = 1.08 \text{ мкм}$$

A_4 ба A_5 мөчүүдийн хэмжээ нь нэгэн ижил хэвийн хэмжээний мужид

оршиж байгаа тул: $A_m = \sqrt{A_{\max} * A_{\min}} = \sqrt{30 * 50} = 38.73$ мм

$$i_{A_4} = i_{A_5} = 0.45 * \sqrt[3]{38.73} + 0.001 * 38.73 = 0.45 * 3.38 + 0.03873 = 1.56 \text{ мкм}$$

A_6 мөчийн хувьд: $A_m = \sqrt{A_{\max} * A_{\min}} = \sqrt{18 * 30} = 23.24$ мм

$$i_{A_6} = 0.45 * \sqrt[3]{23.24} + 0.001 * 23.24 = 0.45 * 2.86 + 0.02324 = 1.31 \text{ мкм}$$

$$\sum_{j=1}^4 i_j = 2 * i_{A_3} + i_{A_4} + i_{A_5} + i_{A_6} = 2 * 1.08 + 1.56 + 1.56 + 1.31 = 6.59 \text{ мкм}$$

- Нийт мөчийн хэмжээний хүлцлийн нэгжийг олбол:

$$\sum_{j=1}^{m+n} i_j = \sum_{j=1}^m i_j + \sum_{j=1}^n i_j = 4.34 + 6.59 = 10.93 \text{ мкм}$$

3. Бүрдүүлэгч мөчүүдийн нийлбэр хүлцлийг олбол:

$$TA_0 - 3 * T_B = 560 - 3 * 120 = 200 \text{ мкм}$$

4. Бүрдүүлэгч мөчүүдийн хүлцлийн нэгжийн тоог олбол:

$$a = \frac{200}{10.93} = 18.3; \quad \text{Энэ утгын стандартын утга нь } a=16$$

болно.

5. Хүлцлийн нэгжийн тоо нь $a=16$ тул [1] номын 1.8 хүснэгтээс харвал бүрдүүлэгч мөчүүд нь IT7 нарийвчлалын ангид хамаарах нь харагдаж байна. Тэгвэл:

$A_1=87.5$ мм;	$TA_1=35$ мкм;	$ESA_1=35$ мкм;	$EIA_1=0$ мкм;
$A_2=102.5$ мм;	$TA_2=35$ мкм;	$ESA_2=35$ мкм;	$EIA_2=0$ мкм;
$A_3=13.5$ мм;	$TA_3=18$ мкм;	$esA_3=0$ мкм;	$eiA_3=-18$ мкм;
$A_4=45$ мм;	$TA_4=25$ мкм;	$esA_4=0$ мкм;	$eiA_4=-25$ мкм;
$A_5=36.5$ мм;	$TA_5=25$ мкм;	$esA_5=0$ мкм;	$eiA_5=-25$ мкм;
$A_6=22.5$ мм;	$TA_6=21$ мкм;	$esA_6=0$ мкм;	$eiA_6=-21$ мкм;
$A_0=14$ мм;	$TA_0=560$ мкм;	$esA_0=1360$ мкм;	$eiA_0=800$ мкм

Мөрдлөг ёсоор бүрдүүлэгч мөч нь ихэсэх(багтаах) бүрдүүлэгч мөч бол хүлцэл нь хязгаарын дээд утгатай тэнцүү, доод хазайлт нь тэгтэй тэнцүү байна гэж үзнэ. Харин багасах (багтах) мөчийн хувьд хүлцэл нь хязгаарын доод утгатай тэнцүү, дээд хазайлт нь тэгтэй тэнцүү гэж үзнэ.

6. Хэмжээний хэлхээсийн өгөгдсөн зураг дээр мөчүүдийн хүлцлийн талбайн зургийг дүрсэлнэ. Хүлцлийн талбайн зургийг зурахдаа хэвийн хэмжээнд багасах масштабыг, хүлцлийн талбайг зурахад ихэсгэх масштабыг хэрэглэнэ.

II. Магадлалын онолын аргаар бодъё.

II.A. Тэнцүү хүлцлийн аргаар бодъё.

1. Бүрдүүлэгч мөчүүдийн хүлцлүүдийг тодорхойлоход хэрэглэх томъёо нь $TA_j = \frac{TA_0 - 3 * T_B}{K_{Ai} * \sqrt{p - 1 - 3}}$ болно. Энд: K_{Ai} -нь тархалтын хууль тооцсон

коэффициент. Үүнийг $K_{Ai} = \frac{6\sigma}{\Delta \text{lim}}$ томъёогоор тодорхойлоно. Δlim -нь тархалтын хуулиас хамаарч:

Гауссийн хуульд: $\Delta \text{lim} = 6\sigma$; $K_{Ai} = 1$. болно.

Тэгвэл:

$$TA_j = \frac{TA_0 - 3 * T_B}{1 * \sqrt{p - 1 - 3}} = \frac{560 - 3 * 120}{1 * \sqrt{11 - 1 - 3}} = \frac{200}{2.65} = 75.4 \approx 75 \text{ мкм болно.}$$

Энэ аргын мөрдлөг ёсоор бүрдүүлэгч мөч нь ихэсэх(багтаах) бүрдүүлэгч мөч бол хүлцэл нь хязгаарын дээд утгатай тэнцүү, доод хазайлт нь тэгтэй тэнцүү байна гэж үзнэ. Харин багасах(багтах) мөчийн хувьд хүлцэл нь хязгаарын доод утгатай тэнцүү, дээд хазайлт нь тэгтэй тэнцүү гэж тооцно. Тэгвэл:

$$\begin{aligned} \Delta SA_1 &= 75 \text{ мкм}; & \Delta IA_1 &= 0 \text{ мкм}; & \Delta SA_2 &= 75 \text{ мкм}; & \Delta IA_2 &= 0 \text{ мкм}; \\ \Delta SA_3 &= 0 \text{ мкм}; & \Delta IA_3 &= -75 \text{ мкм}; & \Delta SA_4 &= 0 \text{ мкм}; & \Delta IA_4 &= -75 \text{ мкм}; \\ \Delta SA_5 &= 0 \text{ мкм}; & \Delta IA_5 &= -75 \text{ мкм}; & \Delta SA_6 &= 0 \text{ мкм}; & \Delta IA_6 &= -75 \text{ мкм}; \end{aligned}$$

II.B. Ижил нарийвчлалын ангийн хүлцлийн аргаар бодлогыг бодъё.

Энэ арга нь стандартын хэмжээнээс бусад бүх бүрдүүлэгч мөчүүдийн хүлцэл нь нэгэн ижил нарийвчлалын ангид хамаарагдана гэж үздэг.

1. Бүрдүүлэгч мөчүүдийн хамаарагдах нарийвчлалын ангийг дараах томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$a = \frac{TA_0 - 3 * T_B}{K_{Ai} * \sqrt{\left(\sum_{j=1}^{m+n} i_j\right)^2}} \text{ болно.}$$

Энд: a - нь хүлцлийн нэгжийн тоо;
 i_j -нь бүрдүүлэгч мөчүүдийн хүлцлийн нэгж, мкм

2. Бүрдүүлэгч мөч бүрийн хүлцлийн нэгжийг олбол:

$$\sum_{j=1}^2 i_{j\text{уухэ}}^2 = i_{A_1}^2 + i_{A_2}^2 = 2.17^2 + 2.17^2 = 9.4178 \text{ мкм}$$

$$\begin{aligned} \sum_{j=1}^4 i_{j\text{багас}}^2 &= 2 * i_{A_3}^2 + i_{A_4}^2 + i_{A_5}^2 + i_{A_6}^2 = 2 * 1.08^2 + 1.56^2 + 1.56^2 + 1.31^2 = \\ &= 2.3328 + 2.4336 + 2.4336 + 1.7167 = 8.9161 \text{ мкм болно.} \end{aligned}$$

$$\sum_{j=1}^2 i_j^2 = 9.417 + 8.9161 = 18.3339 \text{ мкм болно.}$$

3. Бүрдүүлэгч мөчүүдийн нийлбэр хүлцлийг олбол:

$$TA_0 - 3 * T_B = 560 - 3 * 120 = 200 \text{ мкм}$$

4. Тархалтын хуулийг тооцсон коэффициент нь $K_{A_i} = 1$ гэж үзнэ.

5. Бүрдүүлэгч мөчүүдийн хүлцлийн нэгжийн тоог олбол:

$$a = \frac{200}{1 * \sqrt{18.3339}} = \frac{200}{4.2818} = 46.7. \quad \text{Стандартын утга нь } a=40$$

болно.

6. Хүлцлийн нэгжийн тоо нь $a=40$ тул [1] номын 1.8 хүснэгтээс харвал бүрдүүлэгч мөчүүд нь IT9 нарийвчлалын ангид хамаарагдана. Тэгвэл:

$$\begin{aligned} A_1 &= 87.5 \text{ мм}; & TA_1 &= 87 \text{ мкм}; & ESA_1 &= 87 \text{ мкм}; & EIA_1 &= 0 \text{ мкм}; \\ A_2 &= 102.5 \text{ мм}; & TA_2 &= 87 \text{ мкм}; & ESA_2 &= 87 \text{ мкм}; & EIA_2 &= 0 \text{ мкм}; \\ A_3 &= 13.5 \text{ мм}; & TA_3 &= 43 \text{ мкм}; & esA_3 &= 0 \text{ мкм}; & eiA_3 &= -43 \text{ мкм}; \\ A_4 &= 45 \text{ мм}; & TA_4 &= 62 \text{ мкм}; & esA_4 &= 0 \text{ мкм}; & eiA_4 &= -62 \text{ мкм}; \\ A_5 &= 36.5 \text{ мм}; & TA_5 &= 62 \text{ мкм}; & esA_5 &= 0 \text{ мкм}; & eiA_5 &= -62 \text{ мкм}; \\ A_6 &= 22.5 \text{ мм}; & TA_6 &= 52 \text{ мкм}; & esA_6 &= 0 \text{ мкм}; & eiA_6 &= -52 \text{ мкм}; \\ A_0 &= 14 \text{ мм}; & TA_0 &= 560 \text{ мкм}; & esA_0 &= 1360 \text{ мкм}; & eiA_0 &= 800 \text{ мкм} \end{aligned}$$

Мөрдлөг ёсоор бүрдүүлэгч мөч нь ихэсэх(багтаах) бүрдүүлэгч мөч бол хүлцэл нь хязгаарын дээд утгатай тэнцүү, доод хазайлт нь тэгтэй тэнцүү байна гэж үзнэ. Харин багасах(багтах) мөчийн хувьд хүлцэл нь хязгаарын доод утгатай тэнцүү, дээд хазайлт нь тэгтэй тэнцүү гэж үзнэ.

7. Хэмжээний хэлхээсийн өгөгдсөн зураг дээр мөчүүдийн хүлцлийн талбайн зургийг дүрсэлнэ. Хүлцлийн талбайн зургийг зурахдаа хэвийн хэмжээнд багасах масштабыг, харин хүлцлийн талбайг зурахад ихэсгэх масштабыг хэрэглэнэ.

📖 Жишээ. 7. б. /Урвуу бодлого/

Өгөгдсөн нь:

$$\begin{aligned} A_1 &= 14 + 1.3A_4 + B; & A_2 &= 14 + 1.3A_4 + 2B; & A_3 &= 0.3A_4; & A_6 &= 0.5A_4; & A_4 &= 45 \text{ мм}; \\ A_1 &= H_8; & A_2 &= H_9; & A_3 &= g_7; & A_4 &= f_8; & A_5 &= f_8; & A_6 &= g_7; & B &= 15 \text{ мм}; \\ T_B &= 0.12 \text{ мм} \end{aligned}$$

$$A_0 = ?; \quad TA_0 = ?; \quad \Delta SA_0 = ?; \quad \Delta IA_0 = ?$$

Бодолт: I. "Максимум, минимум арга"-аар бодъё.

Бүрдүүлэгч мөчүүдийн хэвийн хэмжээ, хязгаарын хазайлтууд мэдэгдэж байхад хаагч мөчийн хэмжээ, хязгаарын хазайлтыг олно.

1. Бүх мөчийн хэвийн хэмжээсүүдийг олбол:

$$A_1 = 14 + 1.3A_4 + B = 14 + 1.3 \cdot 45 + 15 = 87.5 \text{ мм};$$

$$A_1 = 87.5 \text{ мм};$$

$$A_2 = 14 + 1.3A_4 + 2B = 14 + 1.3 \cdot 45 + 2 \cdot 15 = 106.5 \text{ мм};$$

$$A_2 = 102.5 \text{ мм}$$

$$A_3 = 0.3 \cdot A_4 = 0.2 \cdot 45 = 13.5 \text{ мм};$$

$$A_3 = 13.5 \text{ мм};$$

$$A_6 = 0.5 \cdot A_4 = 0.2 \cdot 45 = 22.5 \text{ мм};$$

$$A_6 = 22.5 \text{ мм};$$

$$A_5 = A_1 - (A_3 + B + A_4/2) = 87.5 - (13.5 + 15 + 22.5) = 36.5 \text{ мм};$$

$$A_5 = 36.5 \text{ мм}; \quad A_0 = A_2 - (A_3 + 2B + A_6 + A_4/2) = 102.5 - (13.5 + 2 \cdot 15 + 22.5 + 22.5) = 14 \text{ мм}$$

2. Бүрдүүлэгч мөчүүдийн хязгаарын хэмжээсүүдийг олбол:

A_1 хэмжээний хувьд:

$$H_8: \quad ES = 54 \text{ мкм}; \quad EI = 0 \text{ мкм};$$

$$TA_1 = 54 \text{ мкм}$$

$$A_{1\max} = A_1 + ES = 87.5 + 0.054 = 87.554 \text{ мм};$$

$$A_{1\max} = 87.554 \text{ мм}$$

$$A_{1\min} = A_1 + EI = 87.5 + 0 = 87.5 \text{ мм};$$

$$A_{1\min} = 87.5 \text{ мм}$$

A_2 хэмжээний хувьд:

$$H_9: \quad ES = 87 \text{ мкм}; \quad EI = 0 \text{ мкм};$$

$$TA_2 = 87 \text{ мкм}$$

$$A_{2\max} = A_2 + ES = 102.5 + 0.087 = 102.587 \text{ мм};$$

$$A_{2\max} = 102.587 \text{ мм}$$

$$A_{2\min} = A_2 + EI = 102.5 + 0 = 102.5 \text{ мм};$$

$$A_{2\min} = 102.5$$

мм

A_3 хэмжээний хувьд:

$$g_7: \quad es = -6 \text{ мкм}; \quad ei = -24 \text{ мкм};$$

$$TA_3 = 18 \text{ мкм}$$

$$A_{3\max} = A_3 + es = 13.5 - 0.006 = 13.494 \text{ мм};$$

$$A_{3\max} = 13.494 \text{ мм}$$

$$A_{3\min} = A_3 + ei = 13.5 - 0.024 = 13.476 \text{ мм};$$

$$A_{3\min} = 13.476 \text{ мм}$$

A_4 хэмжээний хувьд:

$$f_8: \quad es = -25 \text{ мкм}; \quad ei = -64 \text{ мкм};$$

$$TA_4 = 39 \text{ мкм}$$

$$A_{4\max} = A_4 + es = 45 - 0.025 = 44.975 \text{ мм};$$

$$A_{4\max} = 44.975 \text{ мм}$$

$$A_{4\min} = A_4 + ei = 45 - 0.064 = 44.936 \text{ мм};$$

$$A_{4\min} = 44.936 \text{ мм}$$

A_5 хэмжээний хувьд:

$$f_8: \quad es = -25 \text{ мкм}; \quad ei = -64 \text{ мкм};$$

$$TA_5 = 39 \text{ мкм}$$

$$A_{5\max} = A_3 + es = 36.5 - 0.025 = 36.475 \text{ мм};$$

$$A_{5\max} = 36.475 \text{ мм}$$

$$A_{5\min} = A_3 + ei = 36.5 - 0.064 = 36.436 \text{ мм};$$

$$A_{5\min} = 36.436 \text{ мм}$$

A_6 хэмжээний хувьд:

$$g_7: \quad es = -7 \text{ мкм}; \quad ei = -28 \text{ мкм};$$

$$TA_6 = 21 \text{ мкм}$$

$$A_{6\max} = A_6 + es = 22.5 - 0.007 = 22.493 \text{ мм};$$

$$A_{6\max} = 22.493 \text{ мм}$$

$$A_{6\min} = A_6 + ei = 22.5 - 0.028 = 22.472 \text{ мм};$$

$$A_{6\min} = 22.472 \text{ мм}$$

B хэмжээний хувьд:

$$es = 0 \text{ мкм}; \quad ei = -120 \text{ мкм};$$

$$T_B = 120 \text{ мм}$$

$$B_{\max} = B + es = 15 + 0 = 15 \text{ мм};$$

$$B_{\max} = 15 \text{ мм};$$

$$B_{\min} = B + ei = 15 - 0.12 = 14.88 \text{ мм}; \quad B_{\min} = 14.88 \text{ мм}$$

3. Хаагч мөчийн хэмжээний хязгаарын утгуудыг олбол:

$$A_{0\max} = (A_{1\max} + A_{2\max}) - (2 \cdot A_{3\min} + A_{4\min} + A_{5\min} + A_{6\min} + 3 \cdot B_{\min}) = (87.554 + 102.587) - (2 \cdot 13.476 + 44.936 + 36.436 + 22.472 + 3 \cdot 14.88) = 190.141 -$$

$$-175.436 = 14.705 \text{ мм}; \quad A_{0\max} = 14.705 \text{ мм}$$

$$A_{0\min} = (A_{1\min} + A_{2\min}) - (2 \cdot A_{3\max} + A_{4\max} + A_{5\max} + A_{6\max} + 3 \cdot B_{\max}) =$$

$$= (87.5 + 102.5) - (2 \cdot 13.494 + 44.975 + 36.475 + 22.493 + 3 \cdot 15) = 190 - 175.931 = 14.069 \text{ мм};$$

$$A_{0\min} = 14.069 \text{ мм}$$

Хаагч мөчийн хүлцэл, хязгаарын хазайлтыг тодорхойлбол:

$$TA_0 = A_{0\max} - A_{0\min} = 14.705 - 14.069 = 0.636 \text{ мм} = 636 \text{ мкм}$$

$$esA_0 = A_{0\max} - A_0 = 14.705 - 14 = 0.705 \text{ мм} = 705 \text{ мкм}$$

$$eiA_0 = A_{0\min} - A_0 = 14.069 - 14 = 0.069 \text{ мм} = 69 \text{ мкм}$$

4. Хэмжээний хэлхээсийн өгөгдсөн зураг дээр мөчүүдийн хүлцлийн талбайн зургийг дүрсэлнэ. Хүлцлийн талбайн зургийг зурахдаа хэвийн хэмжээнд багасах масштабыг, харин хүлцлийн талбайг зурахдаа ихэсгэх масштабыг хэрэглэнэ.

II. Магадлалын онолын аргаар бодолтыг хийе.

1. Энэ аргаар бодох тохиолдолд хаагч мөчийн хэвийн хэмжээг өмнөх байдлаар тодорхойлсны дараа түүний хүлцэл ба хязгаарын хазайлтуудыг

$$TA_0 = K_{Ai} \sqrt{\sum_{j=1}^{m+n} T_{Aj}^2} \text{ гэж тодорхойлно.}$$

Алдааны тархалтыг Гауссийн хуулинд захирагдана гэж үзээд хаагч мөчийн хүлцлийг тодорхойлбол:

$$TA_0 = 1 \cdot \sqrt{TA_1^2 + TA_2^2 + 2 \cdot TA_3^2 + TA_4^2 + TA_5^2 + TA_6^2 + 3 \cdot T_B^2} =$$

$$= \sqrt{54^2 + 87^2 + 2 \cdot 18^2 + 39^2 + 39^2 + 21^2 + 3 \cdot 120^2} = 240.45$$

$$TA_0 = 240.45 \text{ мкм}$$

болно.

2. Хаагч мөчийн хэмжээний дээд ба доод хязгаарын хазайлтуудын ерөнхий утгыг өмнөх жишээ.9.б-гээс олбол:

$$es' A_0 = \sum_{j=1}^2 ESA_{j\max} - \sum_{j=1}^5 eiA_{j\max} = (54 + 87) - ((-24) \cdot 2 - 64 - 64 - 28 + 3(-120)) = 468 \text{ мкм}$$

$$ei' A_0 = \sum_{j=1}^2 EIA_{jмхэс} - \sum_{j=1}^5 esA_{jбагас} = (0 + 0) - ((-6) * 2 - 25 - 25 - 7 + 3 * 0) = 45 \text{ мкм}$$

3. Дээрх олсон хязгаарын утгуудыг хооронд нь нэмээд 2-т хуваавал хязгаарын хазайлтын дундаж утга гарна:

$$e_m A_0 = \frac{es' A_0 + ei' A_0}{2} = \frac{468 + 45}{2} = 256.5 \text{ мкм}$$


4. Хаагч мөчийн хэмжээний дээд ба доод хязгаарын хазайлтуудын бодит утгыг олбол:


$$esA_0 = e_m A_0 + TA_0/2 = 256.5 + 240.45/2 = 256.5 + 120.225 = 376.725 \text{ мкм}$$


$$eiA_0 = e_m A_0 - TA_0/2 = 256.5 - 240.45/2 = 256.5 - 120.225 = 136.275 \text{ мкм}$$

5. Хэмжээний хэлхээсийн өгөгдсөн зураг дээр мөчүүдийн хүлцлийн талбайн зургийг дүрсэлнэ. Хүлцлийн талбайн зургийг зурахдаа хэвийн хэмжээнд багасах масштабыг, харин хүлцлийн талбайг зурахдаа ихэсгэх масштабыг хэрэглэнэ.

Дээрх жишээн дээр шууд бодлогоос нэг, урвуу бодлогоос тус бүр нэг нэг хүлцлийн талбайн зургийг доорх байдлаар харуулав.







Далгавар № 8.

Бэхэлгээний нүхний тэнхлэг хоорондын зайн хүлцлийн тооцоо

Эд ангиудыг эрээсэн холбоосоор холбож, бэхлэхэд зориулсан нүхнүүдийн төв хоорондын зайн хүлцлийн утгыг зөв сонгон авч, угсрагдах нөхцлийг хангах тооцоо, аргачлал эзэмшүүлэх зорилготой.

Бэхэлгээний "А" төрлийн холбоосыг сондгой тоон шифртэй оюутнууд, "Б" төрлийн холбоосыг тэгш тоон шифртэй оюутнууд тус тус сонгон авч тооцоо хийнэ. Даалгаврыг дараах дарааллаар хийнэ. Үүнд:

1. Өгөгдсөн зургууд нь бэхэлгээний нүхний харилцан байршилын ямар ангиудыг харьяалагдахыг тодруулан бичиж тэмдэглэнэ.

2. Бэхэлгээний нүх ба боолт хоёрын хоорондын хамгийн бага зай- S_{\min} утгыг, мөн нүхний диаметр(D)-ийг [1] номын 2.47 хүснэгтээс боолтын диаметрээс нь хамааруулан авна.

3. Бэхэлгээний нүхнүүдийн төв хоорондын зайн хүлцлийн утгыг нь нүхний харилцан байршилын анги болон S_{\min} - ийн утгаас хамааруулан "А" төрлийн холбоосын хувьд [1] номын 2.49 хүснэгтээс, "Б" төрлийн холбоосын хувьд [1] номын 2.50 хүснэгтээс, өнцгийн хүлцлийн утгыг "А" төрлийн холбоосын хувьд [1] номын 2.51 хүснэгтээс, "Б" төрлийн холбоосын хувьд [1] номын 2.52 хүснэгтээс тус тус сонгон авна.

4. Сонгон авсан утгуудаар хүлцлийн талбайн зургийг өгөгдсөн зураг дээр дүрсэлнэ.

Өгөгдсөн нь:

$$d = 12 \text{ мм}; \quad L = L_X = 36 \text{ мм}; \quad L_1 = L_X * 0.5 \quad L_2 = 2 * L_1; \quad L_3 = 3 * L_1; \quad L_4 = 4 * L_1 \\ L_Y = 0.75 * L_X; \quad \alpha = 60^0; \quad D_1 = d + 3; \quad D_2 = 3 * D_1; \quad D_3 = D_2 + 40 \text{ мм} \\ \delta L = ?; \quad \delta \alpha = ?;$$


Бодолт:

1. Эхний таван зураг нь тэгш өнцөгт координатын системд, сүүлийн нэг зураг нь туйлын координатын системд хамаарагдана.




2. Бэхэлгээний боолтын диаметр $d = 12$ мм бол нүхний диаметр нь $D = 13$ мм болно. Тэгвэл $S_{\min} = D - d = 13 - 12 = 1$ мм болно.



3. Төв хоорондын зайн хүлцлийг $S_{\min} = 1$ мм байхад сонгон авбал:

II ангийн L хэмжээний хувьд:	$\delta L = 1$ мм
III ангийн $L_1; L_2; L_3$ хэмжээний хувьд:	$\delta L_{\Sigma} = 0.35$ мм
IV ангийн $L_1; L_2; L_3; L_4$ хэмжээний хувьд:	$\delta L = 0.35$ мм
V ангийн $L_X; L_Y$ хэмжээний хувьд:	$\delta L = 0.7$ мм
VI ангийн $L_X; L_Y$ хэмжээний хувьд:	$\delta L = 0.35$ мм
X ангийн α өнцгийн хувьд:	$\delta \alpha = 4^0$



Бэхлэгэний нүхний ерөнхий бүдүүвч





I. Үндсэн ойлголтууд, нэр томъёонууд

1	Нэр томъёо ба тодорхойлолт	1	Нэр томъёо ба тодорхойлолт
1	Хэмжээ: шугаман хэмжээний тоон утга. Жишээ нь: (D, d, L, l, B, b, H, h) г.м.	2.5	Дундаж хазайлт: Дээд ба доод хазайлтуудын арифметик дундаж утга.
1.1	Бодит хэмжээ: эд ангийн хэмжилтээр тогтоосон зөвшөөрөгдөх нарийвчлал бүхий хэмжээ.	2.6	Үндсэн хазайлт: тэгийн шугамтай харьцангуй байрлалтай байгаа хоёр хазайлтын аль нэгийг сонгох ба голлон тэгийн шугамд ойрхон байгаа хазайлтыг авна.
1.2	Хязгаарын хэмжээс: бодит хэмжээ завсарт нь орших зөвшөөрөгдсөн хоёр хязгаарын хэмжээс. Жишээ нь: (D_{\max} , D_{\min} , d_{\max} , d_{\min} , L_{\max} , L_{\min}) г.м.	3	Тэгийн шугам: хэвийн хэмжээг тодорхойлогч хэвтээ шугамыг хэлнэ. Энэ шугамаас дээш нэмэх хазайлтын утгыг, доош хасах хазайлтын утгуудыг авна.
1.3	Хязгаарын хамгийн их хэмжээ: зөвшөөрөгдөх хамгийн их хязгаарын хэмжээ. Жишээ нь: (D_{\max} , d_{\max} , L_{\max}) г.м.	4	Хүлцэл: хамгийн их ба хамгийн бага хязгаарын хэмжээнүүдийн буюу дээд, доод хазайлтуудын ялгавр буюу зөвшөөрөгдөх алдааны тархалт.
1.4	Хязгаарын хамгийн бага хэмжээ: зөвшөөрөгдөх хамгийн бага хязгаарын хэмжээ. Жишээ нь: (D_{\min} , d_{\min} , L_{\min}) г.м.	4.1	Стандартын хүлцэл: Хүлцэл суултын өгөгдсөн систем дэх дурын суулт. Ихэвчлэн "стандартын" хүлцлийг зүгээр "хүлцэл" хэлдэг.
1.5	Хэвийн хэмжээ: хэмжээний хазайлтыг тодорхойлох хэмжээ. Жишээ нь: (D, d, L, l, B, b, H, h)	4.2	Суултын хүлцэл: тухайн холбоосонд байгаа нүх ба голын хүлцлүүдийн нийлбэр.
2	Хазайлт: дурын(хэвийн хэмжээн-ээс бусад) хэмжээ ба хэвийн хэмжээ хоёрын алгебрь ялгавар.	5	Хүлцлийн талбай: хэвийн хэмжээтэй харьцангуй байрлалтай, хамгийн их ба бага хязгаарын хэмжээнүүдээр зааглагдсан, хүлцлийг илэрхийлж буй талбай
2.1	Бодит хазайлт: бодит хэмжээ ба хэвийн хэмжээ хоёрын алгебрь ялгавар.	5.1	Суултын хүлцлийн талбай: хамгийн их зай(чийрга) ба хамгийн бага зай(чийрга)-гаар хязгаарлагдсан хүлцлийн талбай
2.2	Хязгаарын хазайлт: хязгаарын хэмжээ ба хэвийн хэмжээ хоёрын алгебрь ялгавар. Дээд ба доод гэж ялгагддаг.	6	Квалитет(нарийвчлалын анги): нарийвчлалын нэг түвшинд байх бүх хэвийн хэмжээний хүлцлийн иж бүрдэл.
2.3	Дээд хазайлт: хязгаарын хамгийн их хэмжээ ба хэвийн хэмжээ хоёрын алгебрь ялгавар.	7	Хүлцлийн нэгж: хүлцлийг тодорхойлох томъёонд байдаг үржвэр бөгөөд хэвийн хэмжээний муж бүрт өөр өөр утгатай байдаг.
